



СОЁЛЫН ЯАМ

**О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН
ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД**

IV

Улаанбаатар

2022

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд



СОЁЛЫН ЯАМ

**О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН
ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД**

IV

Эрхэлсэн:

Доктор Э.Пүрэвжав

Монгол бичгээс хөрвүүлж галигласан:

Э.Оюунтунгалаг, М.Очирцэнд

Тайлбар зүүлт хийсэн: Э.Пүрэвжав, Б.Лхагважав

ISBN: 978-9919-9852-7-1

Оршил

Хорголжин үсгийн хэвээр хэвлэсэн 23 хуудас бүхий уг зохиолыг 1925 онд бичиж хэвлүүлсэн бөгөөд тухайн үедээ 11 мөнгөний үнэтэй байжээ. Энэхүү зохиолыг судлаачид Онходын Жамьян гүнгийн бусад зохиолоос агуулга, бичсэн аргын хувьд ялгаатай хэмээн бичсэн байдаг.

“Урт өдрийн улиг үгний бичиг” зохиолын оршилд *“Дэлхий дахины олон овгийн улс, өөр өөрийн хэлний үсгийг хэдийд хэн нэртэй хүн зохиосон явдал цөм тодорхой данс буй хэмээмүй. Манай Монгол улсад өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг гаргасан номлол буй боловч ихэд дэлгэрсэнгүй бөгөөд, хүн бүр олж мэдэн чадаагүй ажгуу. Эдүгээ аваас манай Монгол тусгаар улс болон тогтнож эрдэм соёлыг бадруулахыг шамдан хичээж бүхүй цаг тул, сая сурах бага хөвгүүдэд өчүүхэн тус болохыг эрэн хүсэж, манай Монголд өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг товч төдий гаргаж бичсүгэй”* хэмээн бичсэн байх бөгөөд цааш үргэлжлүүлэн дэлхийн бичиг үсгүүдийн үүсэл, гарлын тухай товч дурджээ. Энэ нь тус зохиолыг бичих үндсэн шалтгаан болохын хамт уламжлалт хэл зүйн бичгүүдэд нэгэн хэвээр хуулагдан ирсэн дээрх домгийн баримтад эргэлзэх болсон шалтгаан нь ч болсон бололтой.

Монголын түүхэн сурвалжуудад өөрсдийн уг язгуурыг Энэтхэг, Төвөдийн хаадын үе залгамжаас улируулан бичдэг уламжлал бий. Жамьян гүн энэхүү уламжлалыг тус хэл зүйн бичигтээ тусган, монголын алтан ургийн уг язгуурыг Энэтхэг, Төвөдийн хаадын угсаатай холбон бичихдээ *“... сав ертөнц анх тогтож хүн амьтан сая бүтсэн цагт олны дотроос сонгож өргөмжилсөн Энэтхэгийн газрын Олноо өргөгдсөн хааны үрийн үр Төвөдийн Алтан ширээт хааны нэгэн хөвгүүн Бөртэ чоно хэмээгч, Гоо марал хэмээх охиныг гэргий болгон авч Бурхан халдун уулнаа хүрч ирээд Бид хэмээх Монгол улсад ноён болон сууж. Түүний хорин нэгдүгээр үеийн ач Есүхэй баатрын гэргий Өгэлэнээс төрсөн Тэмүжин хэмээх Чингис хаан. Түүний дөрөвдүгээр хөвгүүн Тулуй. Түүний ахмад хөвгүүн Мөнх хаан. Тэрхүү Мөнх хааны үед, түүний хоёрдугаар хөвгүүн Хубилай сэцэн хааны зургаадугаар дүү Годан ноён Сажа бандида Гунгаажалцан хэмээх ламыг залж тахисан ба тэр цагт Сажа бандида бээр эр хэмээх чанга, эх хэмээх хөндий, эрс хэмээх саармаг гурванаар дөчин дөрвөн үсэг зохиов хэмээн номложухуй”* хэмээн ихэд товчлон бичиж, тус үе залгамжийг өөрийн зохиолтой уялдуулан, Сажа бандидын домогт чиглүүлэн хөтөлжээ. Данзандагва, Агваандандар зэрэг өмнөх үеийн уламжлалт хэл зүйн бичгийг туурвисан мэргэд Монголын хаадын тухай дурдсан нь бий ч түүхэн сурвалжийн уламжлалыг даган Энэтхэг, Төвөдийн залгамжтай Монголын алтан ургийг холбож бичсэн нь үгүй билээ. Үүгээрээ “Урт өдрийн улиг үгний бичиг” нь бусад хэл зүйн бичгүүдээс ялгарах нэгэн онцлогтой болж буй юм.

Ном сударт олонтоо хэвлэгдэж, нийтийн дунд түгээмэл тархсан “Сажа бандида Гунгаажалцан дөрөвдүгээр жарны харагчин туулай жил (1243 он)

хэдрэгний дүрсээр үлгэр болгон монгол бичгийг зохиов” хэмээх домгийн баримтад эргэлзэж, энэ тухайгаа анхлан бичиж нийтлүүлсэн хүн нь Жамьян гүн юм. Тэрээр *“Чингис хааны үед Найманы Таян хааныг дайлж, төрийг аваад европын нэгэн мянган хоёр зуун дөрөвдүгээр оноос эхэлж албаны бичигт уйгур үсэг хэрэглэх болов хэмээсэн ба бас Чингисийн хөшөө чулуунд европын нэгэн мянган хоёр зуун хорин таван онд монголоор бичсэн үсэг бий. Бас Гүюг хаанаас пап ламд илгээсэн тамгын монгол үсгийг еуропын нэгэн мянган хоёр зуун дөчин зургаан онд бичжэхүй. Энэ зэргийг үзвээс бандида Гунгаажалцаныг монгол үсэг зохиовой хэмээхийн урьд монголд өөрийн хэлний үсэг буй бөгөөд хэрэглэж явсан гэрч тэмдэг тодорхой ажгуу”* хэмээн 1204 онд Чингис хаан Найман улсыг эзэлсний дараа монгол бичгийг төрийн албан хэрэгт хэрэглэх болсон, 1225 оны Чингисийн чулууны бичгийг монгол бичгээр сийлсэн, бас Гүюг хааны тамганы бичээсийг дурдаад домогт өгүүлсэн 1243 оны харагчин туулай жилээс өмнө Монголчууд монгол бичгээ хэрэглэж байсан хэмээн баталжээ. Харин домогт өгүүлсэн баримт нь тухайн цагт монголчуудын хэрэглэж байсан бичгийг засаж, дүрмийг тогтоосон хэрэг бололтой хэмээн таамаглажээ. Эдгээр саналыг хожмын судлаачид санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг билээ.

Гүюг хаан Их Монгол улсын төрийг хамаарч асан цаг хугацаа болон Ромын Пап ламд захидал илгээсэн огноо нь 1243 оноос хойш хэдий ч О.Жамьян гүн зохиолдоо “Зүрхэн толт”-ыг бичсэн он цагийн тухай *“бандида Гунгаажалцан болбоос Монгол газраа залагдаж европын нэгэн мянган хоёр зуун дөчин долоон оноос нэгэн мянган хоёр зуун тавин дөрвөн он хүртэл суусан хэмээн түүхэнд бичсэн тул тэр хоорондын хэрэг буй за”* хэмээн бичсэнээс үзэхэд он цагийг тооцоход багахан андуурч байсан бололтой.

О.Жамьян гүн тус зохиолдоо дурдсан өмнөх үеийн түүхэн үйл хэрэг зэргийг нийтийн он тооллын хэдэн онтой дүйж, түүнээс нааш хэдий хугацаа өнгөрснийг тодруулан бичсэн нь тун ч бүтээлч ажил болжээ. Хятад, төвөд, орос (кирилл), манж үсэг болон монголчуудын зохион хэрэглэж байсан али гали, тод зэрэг үсгийг хэн, хэдийд, ямар цагаан толгойг түшиж, ямар зорилгоор зохиосон тухай товчхон бичжээ.

Монгол бичгээ сурах, судлах залууст “Огторгуйн маани”, “Хэлний чимэг”, “Алтан толъ” зэрэг хэл зүйн бичгийг олж үзвээс монгол бичгийн хэлний зөв бичих дүрмийг сурахад хялбар болохын хамт гадаад хэлийг сурч эзэмшихэд тун их дэм болно хэмээсэн зөвлөгөөг мөн дайжээ. Түүнчлэн Гунгаажалцан, Чойжи-Одсэр, Гунгаа-Одсэр нарын “Зүрхний толт”-ыг олж үзэх, судлах хэрэгтэй буйг мөн сануулан бичжээ.

Үүний араас хавсралтаар аргын тоолол болон билгийн тооллын ялгаа, жарныг хэзээнээс тоолох болсон хийгээд билгийн тоололд барс сараас жилийг эхлэн тоолох болсны шалтгаан зэрэг цаг тоолол, зурхайн тухай дурджээ.

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд

Төгсгөлд нь гадаад хэлийг сайн сурах хэрэгтэй ч эхлээд монгол хэл, бичгээ сайн сурах нь юу юунаас илүү чухал хэмээн сануулаад, зөв бичих дүрмийг мэдэхийн ач тус хийгээд сайтар сурч, мэргэжиж эс чадвал учрах гэм хорын тухай тодорхой сурган бичжээ. Мөн монгол бичгийн цагаан толгойг улам төгөлдөржүүлэх, үүний тул харь үгийг тэмдэглэхэд шаардагдах үсэг байваас нэмж болох тухай хойч үеийнхэн, түүний номыг анхааран унших хэн бүхэнд захиж бичжээ.

УРТ ӨДРИЙН УЛИГ ҮГНИЙ БИЧИГ

Хичээнгүйлэн санаваас. Дэлхий дахины олон овгийн улс. Өөр өрийн хэлний үсгийг хэдийд хэн нэртэй хүн зохиосон явдал цөм тодорхой данс буй хэмээмүй. Манай Монгол улсад өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг гаргасан номлол буй боловч ихэд дэлгэрсэн үгүй бөгөөд. Хүн бүр олж мэдэн чадаагүй ажгуу. Эдүгээ аваас манай монгол тусгаар улс болон тогтнож эрдэм соёлыг бадруулахыг шамдан хичээж бүхий цаг тул. Сая сурах бага хөвгүүдэд өчүүхэн тус болохыг эрэн хүсэж. Манай монголд өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг товч төдий гаргаж бичсүгэй. Өгүүлэх нь: Сав ертөнц анх тогтож хүн амьтан сая бүтсэн цагт олны дотроос сонгож өргөмжилсөн Энэтхэгийн газрын олноо хааны үрийн үр Төвөдийн алтан ширээт хааны нэгэн хөвгүүн Бөртэ чоно хэмээгч. Гоо Марал хэмээх охиныг гэргий болгон авч Бурхан Халдун уулнаа хүрч ирээд бид хэмээх Монгол улсад ноён болон сууж. Түүний хорин нэгдүгээр үеийн ач Есүхэй баатарын гэргий Өгэлэнээс төрсөн Тэмүжин хэмээх Чингис хаан. Түүний дөрөвдүгээр хөвгүүн Тулуй. Түүний ахмад хөвгүүн Мөнх хаан. Тэрхүү Мөнх хааны үед. Түүний хоёрдугаар хөвгүүн Хубилай сэцэн хааны зургаадугаар дүү Гүдэн ноён Сажан бандида Гунгаажалцан хэмээх ламыг залж тахисан ба тэр цагт Сажан бандида бээр эр хэмээх чанга, эм хэмээх хөндий, эрс хэмээх саармаг гурванаар дөчин дөрвөн үсэг зохиов хэмээн номложухуй. Тэдгээр үсэг нь аль буй хэмээвээс:

а э и, на нэ ни, ба бэ би, ха хэ хи, га гэ ги, ма мэ ми, ла лэ ли, ра рэ ри, са сэ си, да дэ ди, та тэ ти, жа жэ жи, ца цэ ци, йа йэ йи. ва вэ ви, эдгээр болой.

Хубилай сэцэн хааны гуравдугаар хөвгүүн Чингим тайж. Түүний хөвгүүн Өлзийт хаан. Түүний хөвгүүн Дармабала. Түүний Хайсан хүлэг хаан. Түүний үед Сажийн бандида Чойжи-Одсэр хэмээх ламыг залж тахисан хэмээмүй. Лам тэр бээр Гунгаажалцаны зохиосон дөчин дөрвөн үсгийн дээр *о у ө ү, но ну нө нү, бо бу бө бү, хо ху хө хү, го гу гө гү, мо му мө мү, ло лу лө лү, ро ру рө рү, со су сө сү, до ду дө дү, то ту тө тү, жо жу жө жү, цо цу цө цү, йо йу йө йү* Эдгээр тавин зургаан үсгийг нэмж, үсэг бүрийг долоон төрлөөр нэгэн зуун үсэг болгон зохиов хэмээн Огторгуйн маани хэмээх номлолд гаргажухуй. Монголын язгуур зуун үсэг хэмээн үүнийг өгүүлдэг мэт үү. Долоон төрөл хэмээх нь аль буй хэмээвээс *а э и о у ө ү* мэтийг өгүүлжухуй. Эр хэмээх үсэг аль буй хэмээвээс *а о у* тэргүүтэн дөчин гурав болой.

Эм хэмээх үсэг аль буй хэмээвээс *э ө ү* тэргүүтэн дөчин гурав болой.

Саармаг хэмээх үсэг аль буй хэмээвээс *и ни би* тэргүүтэн арван дөрөв болой.

Бас дэлхий дахинд Игифид /Египет/ хэмээх улсад үсэг үүсгэн гаргаж хэрэглэсэн хэмээмүй. Тэр цагаас эдүгээ хүртэл зургаан мянган илүү жил нөгчсөн хэмээн түүхэнд бичжухуй.

Түүний хойно Финиги /Финик/. Түүний хойно Сири /Сири/. Түүний хойно Согд түүний хойно Уйгур улсад хүрч иртэл өөр өөрийн хэлэнд тааруулан өөр өөр үсэг зохиож хэрэглэсээр ирээд. Дөрөвдүгээр машинд гарсны харагчин туулай жилд манай монголын үсгийг анх зохиож хэрэглэсэн хэмээжүхүй. Тэр жил нь Мөнх хааны үрд Сажа бандида Гунгаажалцаны дөчин дөрвөн үсэг зохиосон жилийг өгүүлсэн мэт үү. Бандида Гунгаажалцан болбоос монгол газраа залагдаж Европын нэгэн мянган хоёр зуун дөчин долоон оноос нэгэн мянган хоёр зуун тавин дөрвөн он хүртэл суусан хэмээн түүхэнд бичсэн тул тэр хоорондын хэрэг буй за. Энэ арван тавдугаар машинд гарсны доторх гал бар жил, Монгол Улсын арван зургаадугаар он бөгөөд европын нэгэн мянган есөн зуун хорин зургаадугаар жил хүртэл зургаан зуун наян гурван он нөгчсөн ажгуу. Үүний урьд манай Монгол Уйгур улсын үсгийг хэрэглэн явсан хэмээмүй. Уйгур улс хэмээгч тархаж түгсэн бөгөөд. Эдүгээ цагийн Монголын дундах Урианхай ястан болбой.

Зарим нь хуучин хэлээ сахиж тагнын Урианхай хэмээгч үлдсэн буй. Зарим нь Хотон лугаа хольцолдож хэлээ мартаад мартаад өөр хэлтэн болбой. Зарим нь Шар Уйгур нартай Шар мөрний тэнд Алшаагийн чинад /цаад/ этгээдэд Уйгур үгээр хэлэлцэж суумуй хэмээжүхүй.

Бас Чингис хааны үед Найманы Таян ханыг дайлж төрийг аваад европын нэгэн мянган хоёр зуун дөрөвдүгээр оноос эхэлж албаны бичигт уйгур үсэг хэрэглэх болов хэмээсэн ба бас Чингисийн хөшөө чулуунд европын нэгэн мянган хоёр хорин таван онд монголоор бичсэн үсэг буй. Бас Гүюг хаанаас пап ламд илгээсэн тамгын монгол үсгийг европын нэгэн мянган хоёр зуун дөчин зургаан онд бичжүхүй.

Энэ зэргийг үзвээс бандида Гунгаажалцаныг монгол үсэг зохиовой хэмээхийн урьд Монголд өөрийн хэлний үсэг буй бөгөөд хэрэглэж явсан гэрч тэмдэг тодорхой ажгуу. Үүгээр бодвоос бандида Гунгаажалцан монголын үсгийг тулгар зохиосон нь бус хуучин бүдүүлэг үсгийг засаж эр эм ба эгшиг гийгүүлэгч зэргийг ялган салгаж тогтоосон хэрэг болов уу хэмээмүй. Мэргэд шүүмжлэх ажаамуй.

Хятадын үсэг болбоос эртний Шюань Юань хуандийн цагт сайд Цан Жие хэмээгч бээр анхан шувууны мөрийг зураглан дүрсэлж зургаан зүйлийн бичиг бичих дүрсийг үүсгэж, байдлыг дагаж санааг авч үсэг тогтоовой. Басхүү түүний үед тэнгэрийн зурхай лугаа нийлүүлэн тооны ухааныг гаргавай. Тэр цагаас эдүгээ хүртэл дөрвөн мянган хэдэн зуун жил нөгчжүхүй.

Төвөдийн үсэг болбоос. Мөн Төвөдийн Соронзон Гомбо хааны үед Томи Самбода-г арван зургаан нөхдийн хамт Энэтхэгийн газраа илгээж, Энэтхэгийн бандида Тэнгэрийн ухааны арслан хэмээхээс дууны ухааныг сурч Төвөдийн хэл лүгээ найруулсан гучин үсгийг зохион гаргаж хэрэглэсэн ба түүнээс хойш нэгэн мянган хэдэн зуун жил нөгчжүхүй.

Орос улсын үсэг болбоос Орос улсын дотор Славян овгийн Кирилл Мифоди хэмээх ах дүү хоёр хүн европын найман зуун хорин долоон оноос найман зуун жаран есөн он хүртэл явсан бөгөөд тэр ах дүү хоёр хүн Сири улсын үсгийг өөрийн хэл лүгээ нийлүүлэн засамжилж орос үсгийг зохиож хэрэглэсэн хэмээмүй. Чухам аль онд болохыг олж чадсангүй. Эдүгээ хүртэл нэгэн мянган нэгэн зуугаад он болсон мэт амуй.

Манж үсэг болбоос европын нэгэн мянган зургаан зуун гучин дөрвөн он бөгөөд Чин улсын анхны сэцэн /тэнгэрийн сэцэн/ хааныг Мүгдэний газраа нийслэж бүхий үед Дахай нэрт багш монгол үсгийг гол болгон дусал бинт нэмж үг аялгууг ялган салгаж манж үсгийг гаргасан ба. Хойно *са (8) чи жи¹*-гийн зэрэг гадаад үсэг зохиож басхүү дэвтрээ² үл нийлэлцэхүй нь буй агаад хоёр үсгийг хавсарч аялгууд нийлүүлэн нэгэн үг болгон уншиж тогтоох тул үүнээс манж үсэг бүрдвэй хэмээжүхүй.

*са (8) чи жи нь манж
су чи жы нь монгол³.*

Бас Энэтхэг Төвөдийн хэл ба Төвөдийн үсэгт найруулан монголоор зохиосон Али галигийн тавин үсэг буй. Үүнийг манай Монголд галиг үсэг хэмээн өгүүлмүй. Энэ нь анхны зохиосон зуун үсэгт оролцсон үгүй ажгуу. Хайсан хүлэг хааны үед Сажийн лам Чойжи-Одсэр бээр Сажа бандидын гаргасан үсгийн дээр сүүлд үсэг тэргүүтэн олныг нэмж монгол хэлээр номыг орчуулж шинэ тугдам гаргавай хэмээсэн ба. Бас Цахарын Лигдэн хутагт хааны үед Ганжуур орчуулахуйд бандида Гунгаа-Одсэр шинэ Зүрхний толт гаргавай хэмээсэн зүйл буй. Бас ч Гунгаа-Одсэр болбоос европын нэгэн мянган зургаан зуун дөрвөн оноос эхлэн нэгэн мянган зургаан зуун гучин хоёр он хүртэл Ганжуур зэрэг ном орчуулах хэргийг оролдож, энэ үед Али гали хэмээх үсгийг монголоор зохиосон мэт амуй. Энэ нь Энэтхэг Төвөдийн үг үсэгт нийлүүлэн зохиосон үсэг ажгуу.

Бас арван нэгдүгээр машид гарсны доторх шороо хулгана жил бөгөөд Чин улсын Эээр засагчийн тавдугаар онд Зая бандида Лувсанпэрэнлэй⁴ монгол үсгийг гол болгон байдлыг бага сага хувилгаж долоон аялгуугаар дуудах Ойрадын Тод хэмээх үсгийг зохиосон хэмээсэн ба эдүгээ хоёр зуун далан

¹ Манж бичигт сүүлд зохиосон “са, чи, жи” зэрэг харь үг тэмдэглэх үсгийн тухай дурджээ. “са” үсгийн ард монгол бичгээр наймын тоо тавьж зүүлтийг тэмдэглэсэн байна. Тус зүүлтээ хуудсын төгсгөлд бус, тухайн цогцолборын ард оруулсан нь эхийн дунд мөр ацалж бичсэн мэт болжээ. Үүнийг бид засалгүй тэр хэвээр авч нэмэлт зүүлтээр тайлбарлав.

² дэвтэрт. Өгөх оршихын тийн ялгалын эртний хэлбэр “-а, -э” нөхцөлтэй бичжээ.

³ Өмнө дурдсанчлан энэ хэсэг нь эх доторх “са (8)” хэмээн бичсэний тайлбар болох юм. Гадаад үгийн “са, чи, жи” үеийг манж болон монгол бичгээр хэрхэн тэмдэглэхийг энэ хэсэгт тайлбарлажээ.

⁴ Зая бандида Намхайжамцын нэрийг Халхын Зая бандида Лувсанпэрэнлэйтэй андуурчээ.

долоон жил нөгчжүхүй Дөрвөн ойрад хэмээх нь Торгууд, Хошууд, Дөрвөд, Хойд дөрвөд овгийн монгол мөн бөгөөд энэхүү Тод хэмээх үсгийг эдүгээ хүртэл хэрэглэсээр амуй.

Бас Чин улсын хаан Тэнгэрийн тэтгэсний үед утга үнэн гүн хэмээх эрдэмтэн сайдын зохиосон дөрвөн зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон хэмээх бичгийн дотор Хятад ба Манжийн үг үсэгт гүйцэлдсэн монголын арван хоёр толгой нэгэн зуун тавин үсэг буй. Үүний дотор монгол үсгийн журмыг таниулан тодорхойлсон нь их л буй.

Бас Монлам Равжамба Данзандагвын зохиосон Зүрхний толгын тайлбар Огторгуйн маани хэмээх номлол ба Алшаагийн Монлам Равжамба Агваандандарын зохиосон Хэлний чимэг хэмээх номлол, Шилийн голын чуулганы Авгын баруун этгээд засгийн хошууны захирагч занги Лхамсүрэнгийн зохиосон Алтан толь хэмээх бичгүүдийг олж үзвээс монгол үсгийн дүрмийг туулган нэвтрүүлж чадах бөгөөд бас ч гадаад улсын хэлээр үсэг бичихүйд асар дутагдах үгүй болж болох болов уу хэмээмүй. Бас Мөнх хаан Хайсан хүлэг хаан Лигдэн хутагт хан нарын үед Сажа бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр Гунгаа-Одсэр нар монгол үсэг зохиохууд гаргасан гурван зүйлийн Зүрхний толгыг олж үзэж чадаагүй тул аливаа хүнд эдгээр Зүрхний толтоос нэгэн нь ч буй бөгөөд хүргэж ирвээс, тэр хүнийг Судар бичгийн хүрээлэнгээс ихэд хүндэтгэн сайшаах явдлыг олон түмэн ардад нийтээр зарлан сонсоё.

Завсрын өгүүлэл

Европын ёсны цаг улирлын тоо болбоос нарны явдлыг дагаж тогтоосон нь болой. Үүнийг аргын улирал хэмээмүй. Нэгэн жил нь гурван зуун жаран таван хоногтой. Христосыг мэндэлсний жилээс үүсгэн тоолсон амуй.

Шар зурхай ба Төвөд зурхайн ёсон хэмээвээс сарны явдлыг дагаж тогтоосон нь болой үүнийг билгийн улирал хэмээмүй.

Машид гарсан хэмээх гал туулай болбоос цагийн хүрдний шашныг Шамбалаас Энэтхэгийн газарт анх залж ирсэн жилээс үүсгэн жараад жилээр хэмжээ болгожухуй.

Бар эзэлсэн сарыг жилийн эх болгосон ёсон болбоос манай монголын Чингис хаан Тангудын Минаг хэмээх хааныг алж, улсыг нь эзлэн аваад хааны гарзыг олсон өлзий хутгийн баясгалант хуримын сар хэмээн хуримлаж бар эзэлсэн сарыг жилийн эх болгов.

Бар хавар, зун, намар, өвөл хэмээх дөрвөн цаг болбоос аливаа түмэн бодис хөврөх, өсөх, хураах, нуух дөрөв мөн бөгөөд. Нэгэн жилийн хорин дөрвөн улирлын эн тэргүүн хаврын уур орох өдөр болбоос жилийн эх болгосон бар сарын шинийн нэгний өмнө хойно арван таван өдрийн дотор тохиолдох мөнх

тогтоол тул тийнхүү түмэн бодис шинэчлэн дэлгэрэх бар эзэлсэн сарыг жилийн эх болгосон учир бээр ийм амуу.

Өгүүлэх нь, манай Монгол улс эрдэм соёл юугаан бадруулахыг нэн ихэд хичээж насан залуу ухаан сэргэлэн багачуудыг гадаадын хэл бичгийн сургуульд явуулж бүхий нь нэн ч сайшаалтай бөгөөд гагцхүү өөрийн үндэстний монгол үсэг бичгийг урьдаар шамдан сурваас зохимуй. Учир юун хэмээвээс гадаад улсын хэл бичигт хэдий боловсорсон боловч монгол үсгийг төсөөлөн мэдэх үгүй болбоос гадаад улсад элэглэгдэх төдий үгүй бас ч нэгэн зүйлийн их хэрэг дутагдах буй за.

Бас хуучин үгэнд зуун *алхам явахуйд урьдаар нэгэн алхмын учрыг мэдвээс сайн* хэмээсэн нэгэн үгийг саналтай биш үү. Бас монгол үсгийн дүрэм нэгэн бөгөөд алинаар бичих боловч хүн мэдмүй. Хүн мэдвээс болох нь тэр хэмээмүй. Үсгийн эр, эм, чанга сул, залгах, дагах ёсыг хайхрах үгүй гарын аясаар бичиж огт болох үгүй. Эрх биш анх тогтоосон нэгэн дүрмийг дагаж бичвээс зохимуй. Бас аливаа бичгийг бичихүйд хүнд танигдах ба, үсгийг бүрэн бичвээс бэрх хэмээж бас болохгүй. Ном бичгийн үсгийн байдал байтугай адгуусан амьтны хөрөг дүрсийг боловч уран сайхнаар зурваас нэрт эрдэмтний тоонд оролцох атал ном бичгийн үсгийг төв тэгшээр уран сайхан бичвээс зохихыг юун өгүүлэх.

Бас зарим нэгэн хүн манай монголын үсэг ялгавар үгүй бүдүүлэг бөгөөд гадаад улсын хэлний үг бичихүйд үсэг дутагдмуй хэмээдэг үг буй мэт бөгөөд монгол үсгийн учрыг нарийнаа ялган мэдэж чадваас монгол хэлний үгийг бичихүйд дутагдах ба ялгагдахгүй болох явдал нэгээхэн бээр үгүй. Гагцхүү европ зүгийн хэлэнд бага сага дутагдах зүйл хааяа төдий байх буй за. Хэдий тийм бөгөөд гадаад улсын хэлийг гүйцэлдүүлмүй хэмээн хуучин монгол үсгийг засаж огт болохгүй. Тун ч энхрийлэн хайрлаваас зохимуй. Харин үсэг нэмж зохиохүйд үл болох газар үгүй болов уу. Учир юун хэмээвээс урьд энэтхэг төвөд ба хятад манжийн үг үсгийг гүйцэлдүүлэхээр өчнөөн төчнөөн үсэг нэмэн зохиож гүйцэлдүүлээд эдүгээ хүртэл хэрэглэсээр бүхийг дээр өгүүлсэн ба гагцхүү манж хятадын захиралд агсан цагт тэдний цаазад баглагдаж Оросын зэрэг европ зүгийн улс лугаа харилцан найрамдаж явсангүй тул тэдний үг үсэгт нийлэлцэх үсэг зохиосон үгүй явсан уу.

Бас манай монгол овогтны дотор гадаад улсын хэлийг өөрийн үндэстний хэл мэт хэлэлцдэг нь олон буй. Аль буй хэмээвээс, баруун Хөх нуур зүгийн монголчууд зарим нь төвөд үгээр хэлэлцмүй.

Хойд буриад зүгийн монголчууд зарим нь орос үгээр хэлэлцмүй.

Зүүн Хөлөн буйр зүгийн монголчууд зарим нь хятад ба манж үгээр хэлэлцмүй.

Өмнө дотоод чуулганы монголчууд зарим нь хятад үгээр хэлэлцмүй.

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд

Энэ мэт гадаад улсын хэлэнд хуваагдан байсаар хуучин монгол хэл бичгээ мэдэх үгүй болохуйд хүрвээс үнэхээр хайрлалтай болов уу хэмээхийг эртнээс сануулья.

Энэ нь хэдий үг нь болхи, утга нь гүехэн боловч их төлөвийг хуучин мэргэдийн номлолоос эрэн түүж бичсэн нь бөгөөд эдүгээ үеийн эрдэм сурах хүүхдэд өчүүхэн тус болохыг хүсэж, өөрөө сурсан эрдэмгүйд ичингүйрэлгүй Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн дарга хэмээх хүнд нэрийг хүлээсэн Халх монголын болхи өвгөн Жамьян хэмээгдэх бээр бичиж, *Урт өдрийн улиг үгний бичиг* хэмээн нэрийдвэй. Үүгээр сая сурах хөвгүүний оюуны аман нээгдэх болтугай.

Urtu edür-ün uliy ügen-ü bičig

Kičiyenggüyilen sanabasu. Delekei dakin-u olan obuγ-un ulus. Öber öber-ün kelen-ü üsüg-i kedüi-dü ken ner-e-tei kümün jokiyaysan yabudal čöm todurqai dangsa bui kememüi. Man-u Mongyol ulus-tur öber-ün kelen-ü üsüg kerkin delgeregsen učir-i γaryaysan nomlal bui bolbaču yekede delgeregsen-ügei bögüd. Kümün büri olju meden čiday-a-edüi ajuyu. edüge abasu man-u Mongyol tusγar ulus bolun toγtaniju erdem soyul-i badarayulqu-yi simdan kičiyejü büküi čay tula. Sayi surqu bay-a köbegüd-tür öčüken tusa bolqu-yi erin küsejü. Man-u Mongyol-dur öber-ün kelen-ü üsüg kerkin delgeregsen učir-i tobči tedüi γaryaju bičisügei. Ögülekü inü. Saba yirtinčü angq-a toγtaju kümün amitan sayi бүтүгсөн чaγ-tur olan-u dotur-ača songyuju ergümjiegsen enedkeg-ün γajar-un olan-a ergügdegsen qayan-u ür-e-yin ür-e töbed-ün altan siregetü qayan-u nigen köbegün börte činu-a kemegči. Gow-a maral kemekü ökin-i gergei bolγan abču burqan γaldun aγulan-a kürčü ireged bide kemekü Mongyol ulus-tur noyan bolun sayuju. Tegün-ü qorin nigedüger üy-e-yin ači Yesükei bayatur-un gergei ögelen-eče törügsen Temüjin kemekü Činggis qayan. Tegün-ü dörbedüger köbegün Tului. Tegün-ü aqmad köbegün Mönške qayan. Terekü Mönške qayan-u üy-e-dür. Tegün-ü qoyaduγar köbegün Qubalai sečen qayan-u jiryuduγar degüü Güdeng noyan saja bandida Güngkaǰalcan kemekü blama-yi jalaju takiγsan ba. Tere čaγ-tu saja bandida ber er-e kemekü čingγ-a. em-e kemekü künde. Ersü kemekü sayarmay γurban-iyar döčün dörben üsüg jokiyabai kemen nomlajuqui. Tedeger üsüg inü ali bui kemebesü.

a e i. na ne ni. ba be bi. qa ke ki. γa ge gi. ma me mi. la le li. ra re ri. sa se si. da de di. ta te ti. ja je ji. ča če či. ia ie ii. wa we. Edeger bolai.

Qubalai sečen qan-u γurbaduγar köbegün Čingim tayiji. Tegün-ü köbegün Öljeyitü qayan. Tegün-ü köbegün Darmabala. Tegün-ü köbegün Qayisang kölüg qayan. Tegün-ü üy-e-dür saja-yin bandida Čoyiji odser kemekü blama-yi jalaju takiγsan kememüi. Blama tere ber Güngkaǰalcan-u jokiyaysan döčün dörben üsüg-ün deger-e o u ö ü. no nu nö nü. bo bu bö bü. qo qu kö kü. γo γu gö gü. mo mu mö mü. lo lu löl lü. ro ru rö rü. so su sö sü. do du dö dü. to tu tö tü. jo ju jö jü. čo ču čö čü. io iu iö iü. Edeger tabin jiryuγan üsüg-i manaju üsüg büri-yi doluγan törül-iyer nigen jayun üsüg bolγan jokiyabai kemen oγtaryui-yin mani kemekü nomlal-dur γaryajuqui. Mongyol-un iγayur jayun üsüg kemen egün-i ögüledeg metü-üü. Doluγan törül kemekü inü ali bui kemebesü. a e i o u ö ü metü-yi ögüledekü. Er-e kemekü üsüg ali bui kemebesü a o u terigüten döčün γurba bolai. Em-e kemekü üsüg ali bui kemebesü e ö ü terigüten döčün γurba bolai.

Sayarmay kemekü üsüg ali bui kemebesü i ni bi terigüten arban dörbe bolai.

Basa delekei dakin-dür igifid kemekü ulus-tur üsüg egüsgen γaryaju kereglegsen kememüi. Tere čaγ-ača edüge kürtel-e jiryuγan mingγan ilegüü jil nöğčigsen kemen teüke-dür bičijüküi.

Tegün-ü qoyin-a finigi. Tegün-ü qoyin-a sirii. Tegün-ü qoyin-a soyda tegün-ü qoyin-a uyiγur ulus-tur kürčü iretel-e öber-ün kelen-dür taγarayulun öber-e üsüg jokiyaju kereglegseger ireged. Dörbedüger masida γaruγsan-u qarayčın taulai jil-dür man-u mongγol-un üsüg-i jokiyaju kereglegsen kemejüküi. Tere jil inü Mōngke qayan-u ür-e-dür saja bandida Gūngajalčan-u döčün dörben üsüg jokiyaysan jil-i ögülegsen metü-üü. Bandida Gūnkajalčan bolbasu Mongγol γajar-a jalaydaγu ibrofa-yin nigen mingγan qoyar γayun döčün doluyan on-ača nigen mingγan qoyar γayun tabin dörben on kürtel-e sayuγsan kemen teüke-dür bičigsen tula tere qoyurundu-yin kereg bui-i-a. ene arban tabuduyar masida γaruγsan-u doturaki γal bars jil. Mongγol ulus-un arban jiryuduyar on böged. Ibrofa-yin nigen mingγan yisün γayun qorin jiryuduyar jil kürtel-e jiryuyan γayun nayan γurban on nöğčigsen aγuyu. Egün-ü urida man-u mongγol uyiγur ulus-un üsüg-i kereglen yabuγsan kememüi. Uyiγur ulus kemegči edüge tarqaju tügegsen böged. Edüge čay-un mongγol-un dumdaki uriyangqai yasutan bolbai.

jarim anu qayučın kele-ben sakiγu tagnu-yin uriyangqai kemegči üledegse bui. jarim anu qotung-luy-a qoličalduju kele-ben martayad öber keleten bolbai. jarim anu šir-a uyiγur ner-e-tei šir-a mören-ü tende alaša-yin činadu edeged-tür uyiγur üge-ber kelelčejü sayumui kemejüküi.

Basa Činggis qayan-u üy-e-dür naiman-u Tiyan qan-i dayilju törü-yi abuyad ibrofa-yin nigen mingγan qoyar γayun dörbedüger on-ača ekilejü alban-u bičig-tür uyiγur üsüg kereglekü bolba kemegsen ba. Basa Činggis-ün kösiy-e čilayun-dur ibrofa-yin nigen mingγan qoyar γayun qorin tabun on-dur mongγolur bičigsen üsüg bui. Basa Güyüg qayan-ača fafa blam-a-dur ilegegsen tamay-a-yin mongγol üsüg-i ibrofa-yin nigen mingγan qoyar γayun döčün jiryuyan on-dur bičijüküi.

Ene jerge-yi üjebesü bandida Gūnkajalčan-i mongγol üsüg jokiyabai kemekü-yin urida mongγol-dur öber-ün kelen-ü üsüg bui bögüd kereglejü yabuγsan gereči temdeg todurqai aγuyu. Egün-iyer bodubasu bandida Gūnkajalčan mongγol-un üsüg-i tulyur jokiyaysan anu busu qayučın бүдүгүлүг üsüg-i jasaγu er-e em-e ba. Egesig geyigülügči jerge-yi ilyan salγaju toydayaysan kereg bolbau kememüi. Merged šügümjilekü aγiyamu.

Kitad-un üsüg bolbasu erten-ü Siuwan Yuwan Quwangdi-yin čay-tur sayid Cang jiyei kemegči-ber angqan sibayun-u mör-i jirumlan türsülejü jiryuyan jüil-ün bičig bičikü türim-i egüsgejü. Bayidal-i dayaju sanay-a-yi abču üsüg toydayabai. Basakü tegün-ü üy-e-dür tngri-yin jiruqai-luy-a neyilegülün toyan-u uqayan-i γaryabai. Tere čay-ača edüge kürtel-e dörben mingγan kedün γayun jil nöğčijüküi.

Töbed-ün üsüg bolbasu. Mön töbed-ün Sorongjan Kambu qayan-u üy-e-dür Tomi Sangbuda-yi arban jiryuyan nügüd-ün qamtu enedkeg-ün γajar-a ilegejü. Enedkeg-ün bandida tngri-yin uqayan-u arslan kemekü-eče dayun-u uqayan-i surču ireged töbed-ün kele-lüge nayirayuluγsan γučin üsüg-i jokiyar γaryaju kereglegsen ba tegün-eče qoyisi nigen mingγan kedün γayun jil nöğčijüküi.

Oros ulus-un üsüg bolbasu. Oros ulus-un todur-a slawiyana-a obuγ-un Giril Miwodi kemekü aq-a degüü qoyar kümün ibrofa-yin naiman jāyun qorin doluyan on-ača naiman jāyun jiranyesün on kürtel-e yabuγsan böged. Tere aq-a degüü qoyar širi ulus-un üsüg-i öber-ün kele-lüge neyilegülün jasamjilaγu oros üsüg-i egüsgen jokiyaju kereglegsen kememüi. Čuqam ali on-dur bolqu-yi olju čidayсан-ügei. Edüge kürtel-e nigen mingyan nigen jāyuyad on boluγsan metü amui.

Manju üsüg bolbasu ibrofa-yin nigen mingyan jiryuyan jiyun γučin dörben on böged Čing ulus-un angqan-u sečen qayan-i Mügdün-ü γajar-a neyislejü böküi üy-e-dür Daqai neretü baysi mongγol üsüg-i γool bolγan dusul bintü nemejü üge ayalaγu-yi ilγan salγaju manju üsüg-i γaryaysan ba. Qoyin-a sa či ji-yin jerge γadayadu üsüg jokiyaju basakü debter-e ülü neyilelčeküi inü bui ayad qoyar üsüg-i qabsurču ayalaγu-dur neyilegülün nigen üge bolγan ungsiju toydayaγu tula egün-eče manju üsüg Būridbei kemejüki.

sa či ji inü manju.

su ci zhi inü mongγol.

Basa enedkeg töbed-ün kele ba töbed-ün üsüg-dür nayirayulun mongγolur jokiyaysan ali kali-yin tabin üsüg bui. Egün-i man-u mongγol-dur kaliγ üsüg kemen ögülemüi. Ene inü angqan-u jokiyaysan jāyun üsüg-tür orulčaysan-ügei aγuyu. Qayisang kölüg qayan-u üy-e-dür s j yin blam-a joyiji-Odser ber. Saγa bandida-yin γaryaysan üsüg-ün deger-e següldü üsüg terigüten olan-i nemejü mongγol kele-ber nom-i orčiyulju sin-e tuydam γaryabai kemegsen ba. Basa čaqar-un Ligden qutuytu qayan-u üy-e-dür kanjur orčiyulqui-dur bandida Günka Odser sin-e jirüken-ü toltu γaryabai kemegsen jüil bui. Basaču Günka Odser bolbasu ibrufa-yin nigen mingyan jiryuyan jāyun dörben on-ača ekilen nigen mingyan jiryuyan jāyun γučin qoyar on kürtel-e kanjur jerge nom orčiyulqu kereg-i olulduγu, ene üy-e-dür ali kali kemekü üsüg-i mongγolur jokiyaysan metü amui. Ene inü enedkeg töbed-ün üge üsüg-tür neyilegülün jokiyaysan üsüg aγuyu.

Basa arban nigedüger masida γaruγsan-u doturaki siroi quluγn-a jil böged čing ulus-un eyeber jasayči-yin tabuduyar on-dur jāy-a bandida Lubsangferinglei mongγol üsüg-i γool bolγan bayidal-i baγ-a saγ-a qubilyaju doluyan ayalaγu-bar dayudaydaqu oyirad-un todū kemekü üsüg-i jokiyaysan kemegsen ba. Edüge qoyar jāyun dalan doluyan jil nögčijüküi dörben oyirad kemekü inü torγud qoošud dörbed. Qoyid dörben obuγ-un mongγol mön böged. Enekü todū kemekü üsüg-i edüge kürtel-e kereglegseger amui.

Basa Čing ulus-un qayan tngri-yin tedkügsen-ü üy-e-dür udq-a ünen güng kemekü erdemten sayid-un jokiyaysan dörben jüil-ün üge qadamal üjeküi-dür kilbar bolγaysan kemekü bičig-ün dotur-a kitad ba manju-yin üge üsüg-tür güičeldügsen mongγol-un arban qoyar toluγai nigen jāyun tabin üsüg bui egün-ü dotur-a mongγol üsüg-ün jirum-i taniyulun todurqayilaysan anu yekel-e bui.

Basa monlam Rabjamba Danjin Dayba-yin jokiyaysan jirüken-ü toltu-yin tayilburi uytaryui-yin mani kemekü nomlal ba. Alaša-yin monlam Rabjamba Aųwang Dandar-un jokiyaysan kelen-ü čimeg kemekü nomlal. Sili-yin ʒool-un ciyulyan-u abay-a-yin barayun eteged jasay-un qusiḡun-u jakiryučı janggi Lhmusürüng-ün jokiyaysan altan toli kemekü bičig-üd-i olju üjebesü mongyol üsüg-ün dürem-i tuḡulyan nebtelejü čidaqu böged basaču ʒadaḡadu ulus-un keleber üge üsüg bičiküi-dür asuru tudaḡdaqu-ügei bolju bolqu bolbau kememüi. Basa Mönḡke qayan Qayisang kölüg qayan Ligden qutuḡtu qan nar-un üy-e-dür Saḡa bandida Günkajarcan Čoyiji Odser Günka Odser nar mongyol üsüg jokiyaqui-dur ʒaryaysan ḡurban jüil-ün jirüken-ü toltu-yi olju üjejü čiday-a-edüi tula aliba kümün-dür edeger jirüken-ü toltu-ača nigen inü čü bui böged kürgejü irebesü tere kümün-i Sudur bičig-ün küriyeleng-eče yekede kündedken sayisiyaqu yabudal-i olan tümen arad-tur neyiteber jarlan sonusqay-a.

ḡabsar-un ögüel.

Ibrofa yosun-u čay ularil-un toḡ-a bolbasu naran-u yabudal-i daḡajū toḡtaḡaysan anu bolai. Egün-i arḡ-a-yin ularil kememüi. Nigen jil inü ḡurban ḡayun jiran tabun qonuy-tai. Kristos-i mendüleḡsen jil-eče egüsḡen toḡulaysan amui.

Šir-a jiruqai ba. Töbed jiruqai-yin yosun kemebesü saran-u yabudal-i daḡajū toḡtaḡaysan anu bolai egün-i bilig-ün ularil kememüi.

Masida ʒaruyсан kemekü ʒal taulai bolbasu čay-un kürdün-ü sašin-i šambahla-ača enedkeḡ-ün ʒaḡar-tur angq-a jalaju ireḡsen jil-eče egüsḡen jirayad jil-iyer kemjij-e bolḡajuqui. Egün-i töbed-ün keleber rabjung kememüi.

Bars ejeleḡsen sar-a-yi jil-ün eki boluyсан yosu bolbasu man-u mongyil-un Činggis qayan tangḡud-un minay kemekü qayan-i alaḡu ulus-i inü ejelen abuyad qayan-u ʒaḡar-i oluyсан öljei qutuḡ-un bayasqulangtu qurim-un sar-a kemen qurimanju bars ejeleḡsen sar-a-yi jil-ün eke bolḡaba.

Basa qabur. jun. Namur. Ebül kemekü dörben čay bolbasu aliba tümen bodas köbürekü. Ösükü. Quriyaqu niyuqu dörben mön böged. Nigen jil-ün qorin dörben ularil-un eng terigün qabur-un aḡur oruqu edür bolbasu. jil-ün eke bolḡaysan bars sar-a-yin sin-e-yin nigen-ü emün-e qoyin-a arban tabun edür-ün dotur-a tokiyalduqu mönḡke toḡtaḡal tula teyin-kü tümen bodas sinečilen delḡerekü bars ejeleḡsen sar-a-yi jil-ün eke bolḡaysan učir basa eyimü amui. Ögülekü inü. Man-u mongyol ulus erdm soyul yuḡan badarayulqu-yi neng yekede kičiyejü nasun jalayu uqayan serḡüleng baḡačud-i ʒadaḡadu-yin kele bičig-ün surḡayuli-dur yabuḡulju böküi inü neng-čü sayisiyaltai böged. ʒaḡčakü öber-ün ündüsün-ü mongyol üsüg bičig-i uridabar simdan surbasu jokimui. Učir ʒayun kemebesü ʒadaḡadu ulus-un kele bičig-tür kedüi bolbasuraysan bolbaču mongyol üsüg-i tö süḡelen medekü-ügei bolbasu ʒadaḡadu ulus-tur eleḡlegdekü tedüi-ügei basaču nigen jüil-ün yeke kereḡ dutaḡdaqu bui-i-a.

Basa qayučin ügen-tür жагун алқум yabuqui-dur uridabar nigen алқум-un učir-i medebesü sayin кемегсен nigen үге-yi саналтай бisiü. Basa mongyol үсүг-үн дүрим nigen бөгед. Alin-iyar биçикү болбаçu күмүн medemüi. Күмүн medebesü болқу anu tere кемемү үсүг-үн er-e em-e çingγ-a sula. жағақу. Dayaqu yosu-yi қайықурқу-үгеi γар-un аyas-iyar биçижү оγту болқу-үгеi. Erkebesi anqγ-a тоγтаγсан nigen дүрим-i даγажу биçibesü жокимui. Basa aliba биçиг-i биçикүi-dür күмүн-dür тануγдақу ба. Üсүг-i бүрин биçibesü baraba кемежү basa болқу-үгеi. Nom биçиг-үн үсүг-үн байидал байитуγай адаγусун amitan-u көрүг дүрсү-yi болбаçu uran sayiqan-iyar жiрубасу neretü erdemten-ü тоγан-dur orulçaqu atal-a. nom биçиг-үн үсүг-i төб tegsi-ber uran sayiqan биçibesü жокiqu-yi γаγун өгүлекү.

Basa жарим nigen күмүн man-u mongyol-un үсүг илγабур-үгеi Бүдүгүлiг бөгед. Гадаγаду улус-un келен-ү үге биçикүi-dür үсүг дутаγдамui кемедег үге бui метү бөгед. Mongyol үсүг-үн učir-i narin-a илγан медежү çидабасу mongyol келен-ү үге-yi биçикүi-dür дутаγдақу ба. илγаγдақу-үгеi болқу yabudal негекек бер-үгеi. Гаγçакү ибарофа жүг-үн келен-dür баγ-a саγ-a дутаγдақу жүил қай-a tedüi байиқу бui-i-a. kedüi teyimü бөгед. Гадаγаду улус-un ке-ле-yi гүиçeldүгүлүмüи кемең қайуčin mongyol үсүг-i жасажу оγту болқу-үгеi. Tungçu engkürüyilen қайрлбасу жокимui. Qarin үсүг немежү жокияқуи-dur үлү болқу γаγар-үгеi болbau. Uçir γаγун кемебесü. Urida enedkeg төбед ба. Kitad манжу-yin үге үсүг-i гүиçeldүгүлкү-ber өçinen дөçinen үсүг nemen жокияжу гүиçeldүлүged едүге күртел-e кереглегсеγер бөкүi-yi дегер-e өгүлегсен ба. Гаγçакү манжу kitad-un жакирул-dur аγсан çаγту теден-ү çаγажа-dur байлаγдажу Oros-un жерге ибарофа жүг-үн улус луγ-a қарилчан найрамдажу yabuγсан-үгеi тula. Teden-ү үге үсүг-tür neyilelçekü үсүг жокияγсан –үгеi yabuγсан-uu.

Basa man-u mongyol obuγtan-u dotur-a γадаγаду улус-un ке-ле-yi öber-үн үндүсүн-ү ке-ле метү ке-леlçедег инү olan бui. Ali бui кемебесü. Baraγun көке наγур жүг-үн mongyolçud жарим anu төбед үге-ber ке-леlçемüи.

Qoyidu бuriγад жүг-үн mongyolçud жарим anu oros үге-ber ке-леlçемüи.

жегүн Kөлүн buyir-un mongyolçud жарим anu kitad ба манжу үге-ber ке-леlçемüи.


Emün-e dotuγаду çiyuγан-u mongyolçud жарим anu kitad үге-ber ке-леlçемüи.


Ene метү γадаγаду улус-un келен-dür қубийаγдан аγсаγар қайуčin mongyol ке-ле биçиг-иγан медекү-үгеi болқуи-dur күрбесü үнекер қайрлалтай болbau кемекү-yi ертекек-еçe санаγулuy-a.

